



Бамбай булчирхайн багц шинжилгээний бэлтгэл

Цусны шинжилгээний бэлтгэл:

- Өлөн байх /8–12 цагийн турш хоол идээгүй болон газтай болон чихэрлэг ундаа, зөгийн бал болон чихэртэй цай уугаагүй байх/
- 24 цагийн өмнөөс архи согтууруулах ундаа хэрэглээгүй, өөх тос ихтэй хоол идээгүй байх , биеийн хүчний дасгал болон хэт ачаалал аваагүй байвал илүү тохиромжтой.
- Цусны шинжилгээ өгөхөөс өмнө 15 минут орчим тайван суух хэрэгтэй.
- Цус өгөхийн өмнө эхо, дуран, рентген зэрэг багажийн шинжилгээнд ороогүй, судсаар тодосгогч бодис хэрэглээгүй байна.

Зүрхний бичлэг: Зүрхний бичлэг хийлгэхээс өмнө шатаар дээш доош хурдан алхаагүй, гүйгээгүй байх ба хэрвээ ямар нэгэн ачаалал авсан бол 5–10 минут орчим тайван сууна.

Бамбайн эхо: өвөрмөц бэлтгэл байхгүй.

Жич: Дээрх шинжилгээний хариу гарсны дараа нэмэлт шинжилгээ шаардлагатай бол төлбөр тусдаа тооцогдоно.
Бусад нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлага гарвал 7 хоног дотор үзлэгийн төлбөрөөс 50%–ийн хөнгөлөлт эдлүүлнэ.

